 4. Метилтестостерон уух
 5. Phalloplasto
- /155./ Сэрлийн эмгэгийг нэрлэнэ үү?
1. Хэт сэрэх
 2. Сэрэл буурах
 3. Сэрэл байхгүй байх
 4. Парастези
 5. Сенестопати
- /156./ Шизофрени болон шизофрени төст эмгэгүүдийн ангилалыг нэрлэнэ үү?
1. Шизофренийн хэвшинжит эмгэг
 2. Байнга дэмийрэх эмгэг
 3. Түр зуурын цочмог солиорох эмгэг
 4. Нөлөөтөн дэмийрэх эмгэг
 5. Шизофрениаффектив солиорол
- /157./ Эмнэлзүйн ярилцлагын асуумж нь ямар байдлаас хамааран янз бүр байж болох вэ?
1. Сэтгэцийн эмгэг нэг бүр өөр хоорондоо эмгэг жамын холбоотой шинжүүдээс хамаарах
 2. Илэрсэн шинж тэмдэг бүрийг тодруулах
 3. Шийдвэрлэх асуудлаасаа хамаарах

4. Шинж тэмдэг бүрийн илрэлийг ялгаатай байдлаас хамаарах
 5. Эмнэлзүйн ярилцлагын зорилгоос хамаарах
- /158./ Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын судлах зүйлийг дурьдана уу?
1. Сэтгэцийн эмгэгийн улмаас хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоох
 2. Сэтгэцийн өвчтөнд албадлагын чанартай арга хэмжээ авах
 3. Сэтгэцийн хуурамч өвчлөлийг илрүүлэх
 4. Зарим эмгэгийн эмнэлзүйн хэлбэрийг тогтоох
 5. Иргэний эрхзүйн чадамжийг тогтоох
- /159./ Мансууруулах бодисын хэрэглээг зогсоох бодолгүй байгаа хүнд ямар зөвлөгөө өгөх вэ?
1. Тэднийг буруутган зэмлэж болохгүй
 2. Мансууруулах бодисыг хэрэглэснээс шалтгаалан үүсэх сэтгэлзүйн, нийгмийн эрүүл мэндийн асуудлуудыг тодорхой жишээн дээр хэлж өгөх
 3. Амжилт бүрийг сайшаах
 4. Өвчний дахилтад хүргэсэн нөхцөл, шалтгааны талаар ярилцах
 5. Мансууруулах бодис дахин хэрэглэж байгаа эсэхийг хянахын тулд эмчид үзүүлэх
- /160./ Дотор бэлэг эрхтэн үр хөврөлийн хөгжлийн хэд дэх долоо хоногт бүрэлдэн тогтдог вэ?
1. 5 дахь долоо хоногт
 2. 6 дахь долоо хоногт
 3. 6-32 дахь долоо хоногт
 4. 8-10 дахь долоо хоногт
 5. 15-20 дахь долоо хоногт
- /161./ Харих насанд тохиолдох сэтгэцийн болон төрх үйлийн эмгэгүүдийг нэрлэнэ үү?
1. Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтэй эмгэг
 2. Бага далайцын дэмийрэл бүхий эмгэг
 3. Эпилепси
 4. Котарын сэтгэл уналын дэмийрэл бүхий эмгэг
 5. Судасны гаралтай эмгэг
- /162./ Сэтгэцийн хямрал ямар хэлбэрээр илэрч болох вэ?
1. Айж сандрах
 2. Түр зуур солиорох
 3. Амиа хорлох санаа төрөх
 4. Сэтгэл түгших
 5. Төрх үйл өөрчлөгдөх
- /163./ Анагаахын сэтгэл судлалд ямар илрэлүүд байдаг вэ?
1. Энгийн
 2. Гадаад
 3. Шууд
 4. Дотоод
 5. Шууд бус
- /164./ Сэтгэцийн хямралтай үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөнөөс 2 долоо хоногийн дотор байдал нь сайжрахгүй байгаа тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмч рүү явуулах шалгуур нь юу вэ?
1. Өөрийгөө хянах чадваргүй байх
 2. Хачин санаа бодол, буруу итгэл үнэмшилтэй байх
 3. Хий юм харах
 4. Сэтгэл санааны туйлын хүнд байдал бий болох
 5. Ходоод эвгүйрхэх
- /165./ Алексия –тай хүүхдүүдийн уураг тархины ямар хэсгийн үйл ажиллагаа саатдаг вэ?
1. Уураг тархины хэсэг-50
 2. Уураг тархины хэсэг-19
 3. Уураг тархины хэсэг-20
 4. Уураг тархины хэсэг -39

5. Уураг тархины хэсэг -40

/166./ Эдипийн сөрөг бүрдэл гэж юуг хэлэх вэ?

1. Хүү ээжтэйгээ бэлгийн нэгдэлтэй байх
2. Охин ээжтэйгээ бэлгийн нэгдэлтэй байх
3. Охин аавтайгаа бэлгийн нэгдэлтэй байх
4. Хүү аавтайгаа бэлгийн нэгдэлтэй байх
5. Охин (хүү) 2-уулантай нь бэлгийн нэгдэлтэй байх

/167./ Радын хам шинжийн хэлбэрээр илэрдэг оюуны хомсдолын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Арьс нь хуурай барзгар байх
2. Гар хөл нь сайртаж хуурай болох
3. Арьсанд эвэрлэг хайрс хэт ихээр үүсэн зузаарах
4. Нүүр нь холцруутах
5. Уналт таталтын хамшинж илрэх

/168./ Өтлөлтийн солиорол буюу зөнөгрөх өвчнийг тодорхойлох шинжүүдийг тоочно уу.

1. Ухаан тэнэгрэлээр илэрдэг
2. Их тархины гадрын болон гадрын доод хэсгүүдийн анхдагч хатингаршилт, тэжээлийн дутмагшлын улмаас үүсдэг
3. Уураг тархины органик дотоод шалтгаант эмгэг
4. Тархины судасны хатууралт өвчний улмаас үүсдэг эмгэг
5. Хэвийн хөгшрөлтийн явцад үүсдэг эмгэг

/169./ Хошногоны үе шат хэдэн насанд явагддаг вэ?

1. 3-6 нас
2. 0-18 сар
3. 6-12 нас
4. 18 сар- 3 нас
5. 12-18 нас

/170./ Сэтгэц нийгмийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэж чадахгүй бол ямар асуудалтай тулгарах вэ?

1. Зан үйлийн эмгэгээр өвчлөх
2. Неврозоор өвчлөх
3. Осол сүрэлд өртөх
4. Мансуурах бодист донтой болох
5. Амиа хорлох

/171./ Архинд донтох өвчтэй хүнд илрэх сэтгэл санааны байдлыг дурьдана уу?

1. Уур хилэн
2. Ичгүүр
3. Гомдол
4. Айж эмээх
5. Ганцаардмал байдал

/172./ Сэтгэцийн хямралтай үйлчлүүлэгчийг төрөлжсөн мэргэжлийн сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлж эмчлэх ямар шалгуурууд байдаг вэ?

1. Төрх үйлийн өөрчлөлт илрэх
2. Амиа хорлох бодолтой байх
3. Айж сандрах
4. Сэтгэл гутрах
5. Ходоод өвдөх

/173./ Анхдагч дэмийрлийн дэмийрлийн үе шатуудыг дурьдана уу?

1. Сэтгэл түгшилтийн үе шат
2. Дэмийрлээ мэдэх үе шат
3. Дэмийрлээ тайлбарлах үе шат
4. Дэмийрлийн тогтолцоо бүрэлдэх үе шат

5. Дэмиэрэл арилах үе шат
- /174./ Их тархины гадрын доод бүтцийн тэнэгрэлүүдийг нэрлэнэ үү
1. Альцгеймерийн өвчин
 2. Паркинсоны өвчин
 3. Верникийн зөнөг
 4. Гентенгоны хороя
 5. Пикийн өвчин
- /175./ Насанд хүрсэн хүнд илрэх ялимгүй зовлонт үйлдлүүдийг нэрлэнэ үү?
1. Цэвэр цэмцгэр байх, цэвэрлэх ялимгүй зовлонт үйлдэл, ёс заншил
 2. Аливаа зүйлийг эргэн шалгах ялимгүй зовлонт үйлдэл, ёс заншил
 3. Явж буй машин тоолох, машины номер цээжлэх ялимгүй зовлонт үйлдэл
 4. Дэгжин ганган хувцаслах ялимгүй зовлонт үйлдэл, ёс заншил
 5. Шүтэн бишрэх үйлдэл хийх улигт үйлдэл ба залбирал үйлдэх ялимгүй зовлонт үйлдэл, ёс заншил
- /176./ Төрөлхийн гипотиреоз эмгэгтэй хүүхдэд биеийн талаас гарах онцлог өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?
1. Нуруу нь намхан одой байна
 2. Гавал яс нь том, хүзүү нь богинохон бүдүүн
 3. Уруул нь зузаан, хэл том өргөн
 4. Яс хэврэг, шилбэ нь тахир
 5. Арьс сэвсгэр хийгээд цайвар
- /177./ Психосоматик өвчнүүдэд ямар өвчнүүд хамаарах вэ?
1. Артерийн даралт ихсэх өвчин
 2. Бүдүүн гэдэсний шархлаат үрэвсэл
 3. Нейродерматит
 4. Чихрийн шижин өвчний анхдагч хэлбэр
 5. Иценко-Кушингийн хам шинж
- /178./ Эмнэлзүйн харилцааны ямар ямар загварууд байдаг вэ?
1. Шугаман загвар
 2. Эцгийн эрхт ёсны харилцаа
 3. Эргэлтийн загвар, түншлэлийн загвар
 4. Харилцан нөхөрлөлийн загвар
 5. Үйлчлүүлэгч төвтэй харилцаа
- /179./ Өндөр настны зан төлөвийн онцлогоос дурьдана уу?
1. Уймраа яншаа болох
 2. Гомдомхой өөнтөгч болох
 3. Үгүйсгэх үзэлтэй
 4. Хуучинсаг, өнгөрснөө магтдаг
 5. Юм юманд эргэлзэн тээнэгэлзэх
- /180./ Сэтгэл гутрах эмгэгийн ямар хэлбэрүүдийг Амитриптилинээр эмчлэх нь илүү зохимжтой байдаг вэ?
1. Сонгомол хэлбэрийн сэтгэл гутрал
 2. Өвчирхөх шинж бүхий сэтгэл гутрал
 3. Гуниглах сэтгэл зонхилсон сэтгэл гутрал
 4. Сэтгэл түгшилт дамгайлсан сэтгэл гутрал
 5. Сэтгэлийн мэдээ алдах шинж зонхилсон сэтгэл гутрал
- /181./ Эмийг сонгох шалгуурыг дурьдана уу?
1. АУ-ны шаардлага хэрэгцээг хангасан эсэх
 2. Эмийн үйчлэл тохиромжтой эсэх
 3. Хэрэглэхэд хялбар эсэх
 4. Эмийн заавар монгол хэл дээр эсэх
 5. Эмийн бүртгэлд бүртгэгдсэн эсэх

/182./ Юнг сэтгэл зүйн хэв шинжээрээ хүмүүсийг юу гэж ангилсан байдаг вэ?

1. Шизойд
2. Интроверт
3. Эпилептойд
4. Экстраверт
5. Циклойд

/183./ Дасан зохицохуйн хам шинжийн танин мэдэхүйн илрэлийг дурьдана уу?

1. Анхаарал сарних
2. Мартамхай болох
3. Сэтгэн бодох чадвар буурах
4. Улигт бодолд автах
5. Шийдвэр гаргах чадваргүй болох

/184./ Сэтгэцийн хямралыг ямар хэсгүүдэд хуваан авч үздэг вэ?

1. Даван туулах чадвар алдагдах
2. Хямралын хариу урвал сэтгэцийн яаралтай тусламж шаардах байдал болж илрэх
3. Хүлээн зөвшөөрөх
4. Амьдралын эгзэгтэй таагүй тохиолдол бий болох
5. Сэтгэлийн хямрал илрэхгүй байх

/185./ Амиа хорлох аюултай хариу урвалын сэтгэл хөдлөлийн илрэлээс дурьдана уу?

1. Өөрийгөө ганцаардсан хэмээн мэдэрнэ
2. Сэтгэл түгишинэ
3. Айдас хүйдэс хүрнэ
4. Бухимдана
5. Гомдоно

/186./ Ганцаарчлалыг дотор нь хэд ангилдаг вэ?

1. Шизофренийн ганцаарчлал
2. Хүүхдийн ганцаарчлал
3. Хуурамч ганцаарчлал
4. Жинхэнэ ганцаарчлал
5. Органик ганцаарчлал

/187./ Бензодиазепины цочмог хордлогын үеийн авах яаралтай тусламжийг тоочно уу?

1. Бөөлжүүлэх
2. Ходоод угаах
3. Шээс хөөх түргэн үйлдэлтэй эм хэрэглэх
4. Хордлого тайлах шингэнүүдийг венийн судсанд хийх
5. Галоперидол хэрэглэх

/188./ Бага насны хүүхдэд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгүүдийг нэрлэнэ үү

1. Оюуны хомсдол саатлын эмгэг
2. Эргэн балчирдах хам шинж
3. Хөдөлгөөн ихсэх хам шимнж
4. Тэнүүчлэх дон
5. Айдсын хам шинж

/189./ Сэтгэцийн эмгэгийг оношлох үндсэн аргыг нэрлэнэ үү?

1. Чагнах
2. Одоогийн сэтгэцийн байдлыг шалгах
3. Тогших
4. Анамнез авах
5. Шинжилгээ хийх

/190./ Объектийн хэл ямар байдлуудаар илрэх вэ?

1. Олон тооны энгэрийн тэмдэг
2. Тодорхой утгыг бэлэгдсэн шивээсүүд
3. Эсрэг хүйсийн хувцасаар хувцаслах

4. Эрчүүд үсээ буржийлгаж, уруулаа будах
 5. Этгээд чамин хувцас өмсөж гоёх
- /191./ Дислалия –г хэд ангилдаг вэ?
1. Хөдөлгөөний дислалия
 2. Анхдагч дислалия
 3. Олдмол дислалия
 4. Хоёрдогч дислалия
 5. Төрөлхийн дислалия
- /192./ Стрессийн хам шинжийн үед илрэх сэтгэл хөдлөлийг дурьдана уу?
1. Сэтгэл түгших
 2. Уурлаж бухимдах
 3. Ганцаардах
 4. Өөрийгөө буруутгах
 5. Гуниж гутрах
- /193./ Түгээмэл сэтгэл түгших эмгэгийн үед илрэх сэтгэлзүйн зовиуруудыг нэрлэнэ үү?
1. Айх
 2. Түгшүүрлэх
 3. Сандрах
 4. Сэтгэл хөөрөн баясах
 5. Чихэнд хий юм сонсогдох
- /194./ Бэлгийн үйл ажиллагааны эмгэгтэй үйлчлүүлэгчид эмчилгээнд ямар зарчмыг баримтлах вэ?
1. Эмчилгээнд эрэгтэй, эмэгтэй хосууд хамт оролцоно
 2. Хосууд бие биенийхээ бэлгийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг харилцан ойлголцох холбоо тогтоох
 3. Хосууд бэлгийн боловсрол олгох сургалтанд хамрагдана
 4. Бэлгийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх өвөрмөц ур чадварыг эзэмших
 5. “ Гижгийн цэг”-ийг олж сурах
- /195./ Хүнийг дам аргаар итгүүлэн үнэмшүүлэх ямар арга замууд байдаг вэ?
1. Хүний зан үйлийг өөрчлөх
 2. Мэдээлэл хийх
 3. Сургалт сурталчилгааны ажил
 4. Харилцан зөвшилцөх
 5. Ятгах арга
- /196./ Хүйсийн ялгавар үр хөврөлийн хөгжлийн хэд дэх долоо хоногт үүсдэг вэ?
1. 5 дахь долоо хоногт
 2. 6-32 дахь долоо хоногт
 3. 15-20 дахь долоо хоногт
 4. 6 дахь долоо хоногт
 5. 8-10 дахь долоо хоногт
- /197./ Сэтгэхүйн үйлдлүүдийг нэрлэнэ үү?
1. Харьцуулан сэтгэх үйлдэл
 2. Хийсвэрлэн сэтгэх үйлдэл
 3. Нэгтгэн дүгнэх үйлдэл
 4. Хураан сэтгэх үйлдэл
 5. Ангилан сэтгэх үйлдэл
- /198./ Хүний амьдралын нэгэн биеийн (онтогенез) хөгжлийг дотор нь юу гэж ангилдаг вэ?
1. Гаметогенез
 2. Төрөхийн өмнөх онтогенез хөгжил
 3. Бластогенез
 4. Төрсний дараах онтогенез хөгжил

5. Эмбриогенез

/199./ Ой тогтоолтыг үйл ажиллагаагаар нь юу гэж ангилдаг вэ?

1. Тогтоох ой
2. Хадгалах ой
3. Санах ой
4. Танихуй
5. Мартах

/200./ Эриксоны үзэл баримтлалаар 18 сар-3 насанд нийгэм сэтгэлзүйн ямар ямар шинж чанарууд давамгайлан хөгжих боломжтой вэ?

1. Хөдөлмөрч зан чанар
2. Ичиж зовох
3. Бусдаас дутуу байна хэмээх үнэлэмж
4. Биеэ даасан байдал
5. Ижилсүүлэлт

Сорилын зөв хариулт-1

1-D, 2-D, 3-B, 4-B, 5-E, 6-D, 7-E, 8-C, 9-D, 10-C, 11-C, 12-B, 13-D, 14-A, 15-B, 16-D, 17-C, 18-E, 19-D, 20-D, 21-A, 22-D, 23-D, 24-D, 25-D, 26-B, 27-A, 28-C, 29-C, 30-E, 31-C, 32-E, 33-A, 34-E, 35-C, 36-C, 37-D, 38-D, 39-C, 40-A, 41-C, 42-A, 43-C, 44-B, 45-D, 46-C, 47-A, 48-A, 49-A, 50-A, 51-E, 52-A, 53-B, 54-C, 55-E, 56-A, 57-C, 58-E, 59-C, 60-B, 61-A, 62-A, 63-A, 64-B, 65-E, 66-E, 67-B, 68-E, 69-A, 70-E, 71-E, 72-A, 73-A, 74-A, 75-E, 76-C, 77-E, 78-A, 79-B, 80-A, 81-E, 82-B, 83-E, 84-A, 85-A, 86-E, 87-A, 88-E, 89-E, 90-A, 91-A, 92-E, 93-A, 94-D, 95-E, 96-E, 97-E, 98-E, 99-E, 100-E, 101-E, 102-A, 103-D, 104-C, 105-C, 106-B, 107-C, 108-E, 109-D, 110-D, 111-C, 112-D, 113-B, 114-A, 115-D, 116-D, 117-C, 118-A, 119-C, 120-D, 121-D, 122-E, 123-E, 124-E, 125-A, 126-A, 127-B, 128-B, 129-B, 130-C, 131-C, 132-C, 133-C, 134-C, 135-D, 136-E, 137-D, 138-E, 139-C, 140-E, 141-A, 142-E, 143-E, 144-E, 145-C, 146-C, 147-E, 148-B, 149-E, 150-D, 151-E, 152-C, 153-C, 154-A, 155-E, 156-E, 157-A, 158-E, 159-E, 160-D, 161-C, 162-E, 163-C, 164-E, 165-C, 166-C, 167-E, 168-A, 169-D, 170-E, 171-E, 172-C, 173-E, 174-C, 175-E, 176-E, 177-A, 178-E, 179-E, 180-D, 181-E, 182-C, 183-E, 184-C, 185-E, 186-A, 187-E, 188-E, 189-C, 190-E, 191-C, 192-E, 193-A, 194-E, 195-A, 196-D, 197-E, 198-C, 199-E, 200-C,

Сорил-2

1. Сульдлын хамшинжийн үед илрэх үндсэн шинжүүдийг сонгоно уу?
 1. Сульдлын шинж
 2. Сэрэл ихсэх шинж
 3. Нойрны өөрчлөлт
 4. Бухимдах шинж
 5. Гажуу тусгал
2. Мэдэрч, сэтгэж танин мэдэхүйн хүрээний эмгэг өөрчлөлтийн үед илэрч болох хамшинжүүдийг нэрлэнэ үү?
 1. Хий үзэгдэл дэмийрлийн хамшинж
 2. Дэмийрлийн хамшинж
 3. Кандинский-Клерамбогийн хамшинж
 4. Хий үзэгдлийн хамшинж
 5. Тэнэгрэлийн хамшинж
3. Ойгүйдлийн хамшинжийн үед илрэх үндсэн шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Тогтоох ойгүйдлийн шинж
 2. Хойших ойгүйдэл, өмнөх ойгүйдэл хэмээх шинжүүдийн аль нэг буюу аль аль нь үүсэх
 3. Ойн эндүүрэл
 4. Сэтгэл хий хоосон хөөрөн баясах шинж
 5. Танин мэдэхүйн бууралт
4. Бардамнах дэмийрлийн хамшинжийн үед илрэх үндсэн шинжүүдийг нэрлэнэ үү?
 1. Сэтгэцийн автоматизм
 2. Хуурамч буюу фантаз хий үзэгдэл
 3. Агуу ихийн дэмийрлүүд
 4. Зохиомол дурсамж
 5. Сэтгэл хий хоосон хөөрөн баясах (эйфория)
 5. Кандинский- Клерамбогийн хамшинжийн үед илрэх үндсэн шинжүүдийг нэрлэнэ үү?
 1. Сэтгэцийн автоматизм
 2. Хуурамч хий үзэгдэл
 3. Нөлөөлөх буюу мөрдөх бүлгийн дэмийрэл
 4. Дисфори
 5. Сульдал
 6. Истери хам шинжийн үед мэдрэхүйн талаас гарах өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?
 1. Саа саажилт үүсэх
 2. Хараагүй болох
 3. Явж чадахгүй эсвэл зогсож чадахгүй байх
 4. Хэлгүй – дүлий болох
 5. Уналт таталт илрэх
 7. Истери хам шинжийн үед сэтгэцийн талаас гарах өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?
 1. Ойгүйдэл
 2. Хуурамч тэнэгрэл
 3. Бие хүн хуваагдах
 4. Мэгдэн зугтах
 5. Нялхархах болон зэрлэгших шинж
 8. Кататоник дошгирлын эмнэлзүйн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
 1. Сэтгэлийн онгод орсон дошгирол
 2. Гэнэтийн хүчлэгдсэн дошгирол
 3. Хүүхдэрхэх дошгирол
 4. Дуугүй дошгирол
 5. Бүтээлч биш хилэнт дошгирол
 9. Сэтгэл гутралын хамшинжийн үед хослон илэрдэг үндсэн гурван шинжийг нэрлэнэ үү?
 - A. Сэтгэлээр унах шинж+ой тогтоолтын хурд буурах шинж+хөдөлгөөний идэвхи буурах шинж
 - B. Сэтгэл гутрах шинж+сэтгэцийн үйл ажиллагааны идэвхи ба хурд хэвийн боловч +хөдөлгөөний идэвхи буурах шинж
 - C. Сэтгэл гутрах шинж+оюун ухааны үйл ажиллагаа буурах шинж+хөдөлгөөний идэвхи буурах шинж
 - D. Сэтгэл гутрах шинж+сэтгэцийн үйл ажиллагааны идэвхи ба хурд буурах шинж+хөдөлгөөний идэвхи буурах шинж
 - E. Сэтгэл гутрах шинж+сэтгэл хөдлөлийн идэвхи ба хурд буурах шинж+хөдөлгөөний идэвхи буурах шинж
 10. Ганнушкины гурвал шинж ямар хамшинжийн үед илэрдэг вэ?
 - A. Сульдлын хамшинж
 - B. Эмгэг төрхийн хамшинж
 - C. Сэтгэл хөдлөлийн хамшинж
 - D. Истери хамшинж

Е. Сэтгэц органик хамшинж

11-15 дахь сорил: Асуулт хариултыг уялдуулан сонгох сорил

11. Өвчтөний санаа зоригоос хамаарахгүй өөрөө аяндаа үүсэж ер бишийн этгээд, чамин, бүжих маягийн шинж чанаруудтай гэнэтийн үйлдэл хөдөлгөөн хийх нь сэтгэцийн ямар хамшинжийн үед илэрдэг вэ?
12. Өвчтөний санаа зориг, ухамсраас үл хамааран хар аяндаа үүсч, дотоод ертөнцийг бүрэн эзэмдэх боловч өөрөө хар аяндаа замхран арилдаг, байн байн давтан илэрдэг, өвчтөн өөрт илэрч буй шинжүүдийг хэвийн бус сэтгэцийн үзэгдэл гэж шүүмжлэлтэй хандан салах гэж тууштай тэмцэл хийх шинжүүд ямар хамшинжийн үед илэрдэг вэ?
13. Сэтгэцийн ямар хамшинжийн үед өвчтөний булчин чангарч хөших, хөдөлгөөнгүй болох, дуугүй болох гэсэн гурван шинж хослон илрэх вэ?
14. Өвчтөн өөрийн сэтгэцийн дотоод ертөнцийг бүрэн эзэмдсэн тэсгэлгүй дур хүсэл, оргилсон сэтгэл хөдлөлд автан өөрийгөө цагдаж, хянаж чадахгүй, өөрийн мэдэлгүй ямар нэг үйлдэл гэнэт хийхийг нь сэтгэцийн ямар эмгэг өөрчлөлт вэ?
15. Кандинский-Клерамбогийн хамшинж нь олон жилийн дараа ямар хамшинж рүү шилжиж болох вэ?

11-15 дахь сорилын хариулт

- А. Кататоник дошгирол
- В. Гэнэтийн үйлдэл
- С. Ялимгүй зовлонт байдал
- Д. Бардамнах дэмийрэл
- Е. Кататоник хөшил

Шалтгаан хамаарлын сорил

16. Кататоник хөшлийн эмнэлзүй нь булчин хөших, хөшил тайлагдах хэлбэрээр илэрдэг бөгөөд өвчтөний булчин хөших ба хөшил тайлагдах нь тодорхой дэс дарааллаар явагдана. Тиймээс кататоник хөшилтэй өвчтөний булчин нь нүүр зажлуурын булчингаас эхэлж хүзүү, дээд мөчний, цээжний булчингууд чангарч, төгсгөлд нь доод үе мөчний булчингууд хөших ба хөшил тайлагдахдаа доод үе мөчний булчингаас эхэлж хамгийн сүүлд зажлах булчингуудын хөшил тайлагдана.
17. Кататоник хөшил нь гурван үе шатыг дамжин явагдана. Тухайлбал эхний үе нь уян хөшил, дараах нь хөшингө хөшил, хамгийн сүүлд эсрэгшилтэй хөшил илрэх гэсэн дэс дараалалтай үүснэ.
18. Сэтгэц органик хам шинжийг үед илрэх *Вальтер Бюэлийн гурвал шинж* нь оюун ухааны чадвар буурах, ой тогтоолт буурах, сэтгэлээ барьж чадахгүй байх гэсэн 3 шинжээр илэрдэг. Тиймээс уг хамшинж нь дотоод шалтгаант сэтгэцийн эмгэгүүдийн үед илэрдэг.
19. Мансууруулах бодисыг тогтмол хэрэглэхэд хэдэн сар, жилийн дараа түүнд донтох эмгэг үүснэ. Ийм эмгэгийг өөрөөр мансууруулах бодисын шалтгаант хараат байдлын хам шинж гэж нэрлэнэ.
20. Сэтгэцийн өвчин эмгэг болон хамшинж хоёр нь хоорондоо нарийн уялдаа холбоо бүхий өвөрмөц харилцан хамааралтай байдаг. Тиймээс энэхүү хоорондын өвөрмөц харилцан хамаарлыг нь харгалзан үзэж сэтгэц эмгэгийн хам шинжүүд болон сэтгэц, зан үйлийн эмгэгийг үндсэн 7 хүрээнд хуваан авч үздэг.
21. “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуулинд зааснаар сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээнд аль нь хамаарах вэ?
 1. Амьдрах ухаанд сургах
 2. Харилцааны болон хөдөлмөрийн алдагдсан чадварыг сэргээх
 3. Өвчтөний амьдралын чанарыг дээшлүүлэх

4. Оюуны алдагдсан чадварыг сэргээн засах
 5. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг тэжээн тэтгэх
22. Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл хэмээх ойлголтонд аль нь хамаарах вэ?
1. Хүн өөрийгөө хянах чадваргүй болж бусдын эрүүл мэнд, амь насанд хохирол учруулах
 2. Өөрийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах
 3. Нийгэмд хор хохирол учруулах
 4. Санаатайгаар бусдын амь насыг хөнөөх
 5. Согтуугаар бусдыг зодож гэмтээх
23. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлүүдийг нэрлэнэ үү?
1. Анхан шатны тусламж үйлчилгээ
 2. Амбулаторийн тусламж үйлчилгээ
 3. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ
 4. Сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ
 5. Нийгэм хамт олонд түшиглэсэн тусламж үйлчилгээ
24. ЭМС-ын 180 дугаар тушаалын дагуу нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд хэрэглэх номхотгох аргыг хэрэглэж болохгүй тохиолдлыг нэрлэнэ үү?
- A. Сэтгэцэд нөлөөт солиорлын эсрэг эм байхгүй тохиолдолд
 - B. Сэтгэцийн хурц солиорол бүхий үйлчлүүлэгчийг зөөвөрлөх тээвэрлэх үед
 - C. Сэтгэцийн эмгэгийн улмаас сэтгэц хөдөлгөөний дошгиролд орж биеэ барих чадваргүй болсон үед
 - D. Эмчилгээнээс татгалзаж оргох хандлагатай үед
25. Нейролептик хамшинжийн үед биеийн талаас ямар өөрчлөлт илэрдэг вэ?
1. Нүүр хавагнах
 2. Халуурах
 3. Цусны бүлэгнэлт ихсэх
 4. Арьсанд харшлын тууралт гарах
 5. Биеийн халуун буурах
26. Удаан үйлчилгээтэй солиорлын эсрэг эм аль нь вэ ?
1. Тизерцин
 2. Аминазин
 3. Этаперазин
 4. Модитен депо
 5. Альпразолам
27. Сэтгэцийн өвчтөний биологийн засал эмчилгээнд аль нь хамаарах вэ ?
1. Инсулин комын эмчилгээ
 2. Цахилгаанаар таталдуулах эмчилгээ /ЭСТ/
 3. Хоол сойх эмчилгээ
 4. Нойрсуулах эмчилгээ
 5. Сэтгэцэд нөлөөт эмийн эмчилгээ
28. Инсулин эмчилгээний үед ямар шинжүүд илрэх вэ ?
1. Хөлрөх
 2. Өлсөх
 3. Зүрх дэлсэх
 4. Гүйлгэх
 5. Ам цангах
29. Оюун хомсдол, тэнэгрэл өвчнийг ялган оношлоход харгалзан үзэх шинжүүдийг тодорхойлно уу?
1. Өвчин эхэлсэн нас
 2. Өвчнийг үүсгэх шалтгаан

3. Уураг тархины бүтцийн өөрчлөлт байгаа эсэх
4. Сэтгэц эмгэгийн хавсарсан шинжүүд байгаа эсэх
5. Оюун ухааны чадварын түвшин

30. Оюуны хомсдол эмгэгийн ямар тохиолдолд сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай вэ?

1. Оюуны хомсдол нь бие махбодын гаж хөгжилтэй хавсарсан тохиолдолд
2. Уналт таталтын хамшинж илэрдэг бол
3. Өөртөө үйлчлэх энгийн дадал чадвар огт хөгжөөгүй бол
4. Эмчилгээ шаардлагатай төрх үйлийн эмгэг илэрсэн тохиолдолд
5. Нийгмийн дунд бие даан амьдрах чадваргүй бол

31. Оюуны хомсдол эмгэгтэй хүмүүсийн эрхийн тухай тунхагт заасан эрх аль нь вэ?

1. Бусад хүний адил эрхтэй
2. Өөрийн хүч чадалд тохирсон ажилд орох, бүтээлч хөдөлмөр эрхлэх эрхтэй
3. Өөрийн эрх ашгаа хамгаалахын тулд өмгөөлөгч авах эрхтэй
4. Өөрийн эрх ашгаа бүрэн хамгаалж чадахгүй бол хуулийн шинжээчийн тусламжтайгаар эрхээ хамгаалуулах эрхтэй
5. Эмчилгээнээс татгалзах эрхтэй

32. НҮБ-ын Ерөнхий ассамблейн “Сэтгэцийн өвчтэй хүмүүсийг хамгаалах ба сэтгэцийн эрүүл мэндийн сайжруулах талаар баримтлах 25 зарчим”-д заасан эрхүүдийг нэрлэнэ үү?

1. Гэр бүл болох эрхтэй
2. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх эсэх талаар сайн дураараа сонголт хийх эрхтэй
3. Эмчилгээгээ өөрөө сонгох эрхтэй
4. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй
5. Гэрээ хэлцэл хийх эрхтэй

33. Оюуны хомсдол эмгэгийн үед илрэх эмчилгээ шаардлагатай сэтгэц төрх үйлийн өөрчлөлтүүд аль нь вэ?

1. Хулгайн дон
2. Сэтгэц хөдөлгөөний дошгирол
3. Тэнэхийн дон
4. Уналт таталтын хамшинж
5. Архидах дон

34. Сэтгэл зүйн ямар хэвшинжтэй хүн сөрөг стресст өртөх хамгийн өндөр магадлалтай вэ?

- A. Флегматик хэвшинж
- B. Холерик хэвшинж
- C. Меланхолик хэвшинж
- D. Сангвиник хэвшинж
- E. Холимог хэвшинж

35. Дараах хэлбэрийн айдсуудаас аль нь нийгмийн улигт айдаст хамаарах вэ?

1. Нүүр улайхаас айх айдас
2. Хүнээс айх айдас
3. Огиулахаас айх айдас
4. Ходоод гэдэсний хий алдахаас айх айдас
5. Хурьцал үйлдэхээс айх айдас

36. Ганцаараа байхаас айх, түгжээтэй байрнаас айх, могойноос айх, өндрөөс айх зэрэг улигт айдсууд нь Өвчний олон улсын ангилалаар аль ангилалд хамаарах вэ?

- A. Өвөрмөц улигт айдас
- B. Түгээмэл айдас
- C. Нийгмийн айдас
- D. Талбайн айдас
- E. Хавсарсан улигт айдас

37. Сандрах эмгэгийн дайралд автсан үед хийвэл зохих алхмуудыг хэлнэ үү?

1. Тайвшруулах амьсгалын дасгал хийх
2. Анхаарлаа биеийн шинжүүдэд хандуулахгүй байх
3. Өөрийгөө тайвшруулах үгсийг өөртөө хэлэх
4. Дайралт өнгөртөл хаана байгаа газраа байх
5. Амьсгалаа хянаж тоолох

38. Гамшигт нэрвэгдэгсдэд илэрч болох хариу урвалын хэлбэрүүдийг тоочно уу?

1. Уурлаж уцаарлах
2. Сэтгэл гутрал
3. Ичиж зовох
4. Сэтгэл түгшилт
5. Гэмших

39. Гамшгийн үеийн сэтгэлийн шалтгаант сэтгэл гутралын үед илрэх Ясперсийн шинжийг нэрлэнэ үү?

1. Сэтгэлийн цохилт өвчний эмнэлзүйд тусгагдана
2. Сэтгэл гутрал үүснэ
3. Асуудлыг зохистой шийдвэрлэвэл үүссэн шинжүүд арилна
4. Өтгөн хатна
5. Сэтгэхүйн үйл ажиллагаа удааширна

40. Сэтгэлийг ариусгах буюу сэтгэлийг дарамтаас чөлөөлөх сэтгэл заслын аргуудыг нэрлэнэ үү?

1. Харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл засал
2. Сэтгэлийн дарамтат үйл явдлыг дурсан санах
3. Сэтгэцийн драм
4. Цаасан уут руу амьсгалуулах арга
5. Ятгах арга

41-44-р сорил: Асуулт хариултыг уялдуулан сонгох сорил

Өвчний олон улсын ангилалын оношийн код, дараах нэршлийг уялдуулан сонгоно уу?

41. Истерийн мэдрэлийн болон мэдрэхүйн өөрчлөлт

42. Истерийн вегетатив өөрчлөлт

43. Истерийн сэтгэцийн өөрчлөлт

44. Сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгүүд

Хариулт:

- A. F 4
- B. F 44
- C. F 45
- D. F 48

45. Кляйн- Левинийн хамшинж нь нойрны хямралын ямар хэлбэр вэ?

- A. Органик нойргүйдэх эмгэг
- B. Органик хэт нойрсох эмгэг
- C. Органик нойрны дайралт
- D. Үечилсэн хэт нойрсох эмгэг
- E. Амьсгалалт түр зогсох нойрны эмгэг

46. Биеийн хэлбэрийн эмгэг нь биеийн өвчний шинжээр илэрч байгаа сэтгэцийн эмгэг мөн. Иймд өвчтөнийг эмчид хандах бүрт шинжилгээг нарийвчлан хийж биеийн талаас илэрч буй өвчин бүрт тохирсон эмийн эмчилгээ хийнэ.

47. Оюуны хомсдол эмгэг нь үр хөврөл бүрэлдэн тогтохоос эхлээд төрсний дараах 3 нас хүртэлх хугацаанд гадаад, дотоод шалтгааны улмаас оюун сэтгэцийн үйл ажиллагаа дутуу хөгждөг эмгэг учраас эмгэгийн үед үүссэн тэнэгрэлийг хагас болон бүтэн тэнэгрэл гэж оношилно.

48. Төрх үйлийн хямралгүй оюуны хомсдол эмгэгийн үед өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагагүй бөгөөд харин сэтгэц нийгмийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ нь хамгийн чухал эмчилгээний ач холбогдолтой.

49. Сандрах эмгэгийн дайралд өртсөн үед өвчтөний амьсгалын тоо цөөрдөг тул цаасан уут руу амьсгалуулж хэт амьсгалалтыг намжаана.
50. Сэтгэлийн гэмтлийн үед нойрны хямрал үүсдэг ба нойрны хямралыг зөвхөн амитриптилинээр эмчилнэ.

51-54-р асуулт. Уялдуулан сонгох сорил

Сэтгэц эмгэгийн дараах шинжүүдийг уялдуулан сонгоно уу?

51. Бие хүн өөрийн биш болох шинж
52. Орчин өөрчлөгдөх шинж
53. Хувиргаж харах шинж
54. Биеийн тойм өөрчлөгдөх шинж
- A. Хэзээ ч үзээгүйн шинж
 - B. Хоёр зүрх маань нэг нь аавынх, нэг нь ээжийнх хэмээн мэдрэх шинж
 - C. Өрөөний тавилга өндөр, нам болж харагдах шинж
 - D. Өөрийн биеийн жин үгүй болсон мэт мэдрэх шинж

55-59-р асуулт. Уялдуулан сонгох сорил

Дараах солиорлын шинж тэмдэг, хамшинжийн үед илрэх өвөрмөц шинжүүдийг уялдуулан сонгоно уу?

55. Хий үзэгдлийн хамшинж
56. Дэмийрлийн шинж
57. Хий үзэгдэл дэмийрлийн хамшинж
58. Бардамнах дэмийрлийн хамшинж
59. Капграгийн хамшинж
- A. Нөлөөлөхийн дэмийрэл
 - B. Гарз хохирлын дэмийрэл, сонсголын хий үзэгдэл
 - C. Харааны хуурамч хий үзэгдэл, оюун санааны хий үзэгдэл
 - D. Хуурамчаар танин мэдэхүйн гажуу тусгал
 - E. Агуу ихийн дэмийрэл, зохиомол дурсамж

60-64-р асуулт. Уялдуулан сонгох сорил.

Ухамсарт ухаан балартлын өвөрмөц хэлбэрүүдийн үед илрэх онцлог шинжүүдийг уялдуулан сонгоно уу?

60. Ухамсарт ухаан зүүдчилэн балартал
61. Ухамсарт ухаан дэмийрэн балартал
62. Ухамсарт ухаан будангуйран балартал
63. Ухамсарт ухаан нойрмоглон балартал
64. Ухамсарт ухаан бүрийтэн балартал
- A. Бүтэн ойгүйдэл илэрнэ
 - B. Хоёрдмол баримжаалал илэрнэ
 - C. Ор дэрний хүрээний дошгирол илэрнэ
 - D. Рефлексүүд буурч, гадны цочрол хүлээн авах чадвар буурна
 - E. Элбэг дэлбэг хий үзэгдэл, дүрсийн гажуу тусгал тод илэрнэ

65. Ухамсарт ухаан балартлын үед өвчтөн сэтгэц хөдөлгөөний дошгиролд орж болно. Иймд өвчтөн дошгирсон үед номхотгох цамцыг 4 цагаас илүүгүй хугацаагаар өмсүүлж тайвшруулна.

66. Шизофрени өвчин үүсэх шалтгаан бүрэн тогтоогдоогүй. Гэвч уг өвчин үүсэхэд удмын хүчин зүйл, дофамины солилцооны хямрал нөлөөлдөг.

67. Сэтгэлийн хөдөлгөөн цочирдлын хоёр туйлт эмгэгийн эмнэлзүйд сэтгэл хөөрөх, сэтгэл гутрах хамшинж ээлжлэн солигдох байдлаар илэрдэг. Харин уг өвчин нь сэтгэл гутралын хамшинжээр эхлэн илэрдэг онцлогтой.
68. Агаарын гэмтэл нь цаг агаарын таагүй байдлын улмаас үүсдэг. Иймд уг өвчний үед өвөрмөц эмчилгээ байдаггүй.
69. Сэтгэл гутрах эмгэгийн үед нойрны хямрал илэрдэг. Гэвч сэтгэл гутралын үед нойр хасах эмчилгээ хийхэд эмчилгээний үр дүн сайн байдаг.
70. Архины хэрэглээтэй холбоотой эмгэгийг оношлохын тулд ашиглах сорилуудыг нэрлэнэ үү?
1. Мичиганы сорил
 2. AUDIT сорил
 3. CAGE сорил
 4. Fagersrom-ын сорил
 5. Folstein-ны сорил
71. Өвчтөн Э шизофрени өвчний улмаас сэтгэцийн эмнэлэгт олон удаа хэвтэн эмчлүүлж байсан. Өнөөдрийн байдлаар сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэгт харааны болон сонсголын хуурамч хий үзэгдэл, нөлөөлөхийн дэмийрэл, сэтгэц автоматчилагдах шинж илэрч байна. Үндсэн мэргэжлийн эмчид илгээхдээ хамшинжийн ямар онош тавих вэ?
- A. Хий үзэгдэл дэмийрлийн хамшинж
 - B. Холимог хамшинж
 - C. Кандинский Клерамбогийн хамшинж
 - D. Хуурамч хий үзэгдлийн хамшинж
 - E. Шизофренийн хамшинж
72. Сэтгэц мэдрэхүйн өөрчлөлтийн нэг хэлбэр болох орчин өөрчлөгдөх шинжийн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. Аль хэдийнэ үзсэн шинж
 2. Объект эргэх шинж
 3. Огт үзээгүйн шинж
 4. Хуурамчаар таних шинж
 5. Орчин хүнийх болсон шинж
73. Өвчтөн Н 32 настай эрэгтэй. Сэтгэцийн эмнэлэгт анх удаа үзүүлэхээр иржээ. Өвчтөнийг оношлохын тулд сэтгэхүйн үйлдлийн чадварыг шалгах шаардлагатай байна. Иймд сэтгэхүйн үйлдлийн ямар чадварыг шалгах вэ?
1. Тодруулан сэтгэх үйлдэл
 2. Нэгтгэн дүгнэх үйлдэл
 3. Ангилан сэтгэх үйлдэл
 4. Харьцуулан сэтгэх үйлдэл
 5. Хийсвэрлэн сэтгэх үйлдэл
74. Дэмийрэлтэй өвчтөн хуурамч, нотолгоогүй юмс үзэгдлийг өөрийн ертөнцийг үзэх үзэл мэт буруу тайлбарлах ба дэмийрэл нь бүрэлдэн ухуулан сэнхрүүлэх замаар засагдах боломжгүй байна. Өвчтөний дэмийрэл нь дэмийрлийн үе шатны ангилалын дагуу аль үе шатанд байна вэ?
1. Сэтгэл түгшилтийн үед
 2. Дэмийрлэн мэдрэх үе
 3. Дэмийрлээ тайлбарлах үе
 4. Дэмийрлийн тогтолцоо бүрэлдэх үе
 5. Дэмийрэл арилах үе
75. Сэтгэл хөөрлийн хамшинжийн үед ойн ямар чадвар богино хугацаагаар хэвийн хэмжээнээс хэт ихэсдэг вэ?
- A. Хадгалах ойн чадвар
 - B. Санах ойн чадвар

C. Богино хугацааны ойн чадвар

D. Утгын ой тогтоолт

E. Харааны ой тогтоолт

76. Вегетатив буюу далд сэтгэл гутралын үед биемахбодын талаас илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Толгой өвдөх
2. Амьсгал давчдах
3. Яс үе мөч өвдөх
4. Хоолонд дургүй болох
5. Гэдэс ходоод өвдөх

77. Кататони үүсэх шалтгааныг хэрхэн ангилдаг вэ?

1. Дотоод шалтгаант кататони
2. Сэтгэлийн шалтгаант кататони
3. Органик шалтгаантай кататони
4. Ухаан саруул кататони
5. Ухаан зүүдчилэн балартах кататони

78. Шизофрени өвчний үед хий үзэгдэл илэрдэг. Хий үзэгдлийн нэг хэлбэр нь сонсголын хий үзэгдэл мөн. Иймд сонсголын хий үзэгдлийн ангилалыг нэрлэнэ үү?

1. Доромжлох хий үзэгдэл
2. Сонсголын эгэл хий үзэгдэл
3. Захиран тушаах хий үзэгдэл
4. Аман ярианы хий үзэгдэл
5. Зэмлэн буруушаах хий үзэгдэл

79. Ямар хэлбэрийн хий үзэгдэл хавсран илрэхийг Майер-Гроссын хам хий үзэгдэл гэдэг вэ?

1. Харааны хий үзэгдэл
2. Арьсны хий үзэгдэл
3. Сонсголын хий үзэгдэл
4. Хүрэлцэхүйн хий үзэгдэл
5. Эгэл хий үзэгдэл

80. Архины цагаан солио өвчний түрүү үеийн дотор эрхтэний болон вегетатив шинжүүд архийг уухаа тэвчиж цээрлэснээс хойш хэдий хугацааны дараа илрэх вэ?

- A. 2-4 цагийн дараа
- B. 4-6 цагийн дараа
- C. 6-12 цагийн дараа
- D. 8-24 цагийн дараа
- E. 8-48 цагийн дараа

81. Архинд харшил үүсгэх суулгац буюу эспералийг ямар тохиолдолд булчинд суулгаж болохгүй заалттай вэ?

1. Элэгний үйл ажиллагааны хурц ба архаг дутагдал
2. Цусны эргэлтийн өөрчлөлт бүхий зүрх судасны өвчнүүд
3. Хурц үрэвсэлт өвчнүүд
4. Шизофрени өвчтэй хосолсон архаг архидалт
5. Тетурамын (эспералын) солиорол илэрч байсан бол

82. Байнга дэмийрэх эмгэгийн үед олонтаа тохиолддог дэмийрлийн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Системчлэгдсэн мөрдөх дэмийрэл
2. Системчлэгдсэн өвчирхөх дэмийрэл
3. Системчлэгдсэн шинэтгэлийн дэмийрэл
4. Системчлэгдсэн хардах дэмийрэл
5. Системчлэгдсэн зохион бүтээхийн дэмийрэл

83. Кречмерийн биеийн бүтэц, эмгэг зан төлөвийн үзэл баримтлалаар ямар бие галбиртай хүн шизофренигээр өвчлөх магадлалтай гэж үздэг вэ?

- A. Пикник хэвшинж
- B. Лептосом хэвшинж
- C. Дисбласт хэвшинж
- D. Атлет хэвшинж

84. Үр хөврөлийн бүтцийн давхаргын хөгжлийг харгалзан хүмүүсийг хэв шинжид хуваан ангилсан үзэл баримтлалыг хэн боловсруулсан бэ?

- A. Кречмерийн үзэл баримтлал
- B. Эриксоны үзэл баримтлал
- C. Шельдоны үзэл баримтлал
- D. Ганнушкины үзэл баримтлал

85. Нөлөөтөн дэмийрэх эмгэг гэдэг нь солиорол бүхий нэгнээс нөгөөд солио халдварлан үүсэхийг хэлнэ. Иймд солиролтой хүнийг тус тусад нь эмчлэх шаардлагатай.

86. Эмгэг төрх өвчин нь Снежневскийн ангилалаар 2-р хүрээний эмгэгт багтах ба энэ нь өвчний олон улсын ангилалаар насанд хүрсэн бие хүний эмгэгтэй дүйцнэ.

87. Шинж тэмдгийн солио өвчний үндсэн хамшинж нь хий үзэгдэл дэмийрэл бөгөөд сэтгэц эмгэгийн хамшинж, өвчний харилцан хамаарлаар авч үзвэл 1-4-р хүрээний өвчний үед илэрч болно.

88. Насанд хүрсэн бие хүний эмгэгийн нэг хэлбэр нь нийгмийн эсрэг бие хүний эмгэг бөгөөд нийгмийн эсрэг бие хүний эмгэг нь гэр бүлийн буруу хүмүүжлээс шалтгаалан үүсч болно.

89. Абелийн “Толины шинж”, Коркинагийн “Фото зургийн шинж” зэрэг өвөрмөц шинжүүд сэтгэц эмгэгийн ямар өвчний үед сонгомлоор илэрдэг вэ?

- A. Мэдрэлийн хомхой
- B. Бие эрхтэний гажгаас айх эмгэг (диморфофобия)
- C. Хүүхэд насны төрх үйлийн эмгэг
- D. Кляйн Левины хамшинж

90. Архины шалтгаант солиорлыг эмчлэх Поповын уусмалын найрлаганд тайвшруулах, нойрсуулах бүлгийн ямар эмийн бодис хэрэглэдэг вэ?

- A. Элениум
- B. Седуксин
- C. Фенобарбитал
- D. Амитриптилин
- E. Левомепромазин

91. Солиорлын эсрэг эмийн гаж нөлөө болох Паркинсоны хам шинж үүсэхээс сэргийлэх, гаж нөлөөг эмчлэх зорилгоор хэрэглэх психокорректор эм аль нь вэ?

- 1. Циклодол
- 2. Пипольфен
- 3. Димедрол
- 4. Артан
- 5. Паркопан

92. Сэтгэцийн эмгэгтэй өвчтөнийг идэвхижүүлэх дэглэмд хамаарах эмчилгээний төрлийг зөв нэрлэнэ үү?

- 1. Урлаг эмчилгээ
- 2. Хөдөлмөр эмчилгээ
- 3. Эмнэлгийн орчноор эмчлэх эмчилгээ
- 4. Физик, биеийн тамир эмчилгээ
- 5. Номын эмчилгээ

93-97-р асуулт. Уялдуулан сонгох сорил

Амиа егүүтгэлтэй холбоотой дараах нэр томъёог уялдуулан сонгоно уу?

- 93. Хамтын суицид
- 94. Вертерийн хамшинж
- 95. Өргөтгөсөн суицид

96. Суицид

97. Гомицид

A. Хүнийг алах

B. 2 ба түүнээс дээш тооны хүн зөвшилцөж амиа егүүтгэх

C. Даган дуурайж амиа егүүтгэх

D. Ухамсартай шийдвэр гаргаж өөрийн амийг егүүтгэх

E. Эхлээд бусдыг егүүтгэж дараа нь өөрийгөө егүүтгэх үйлдэл

98. Кататоник дошгирлын үед өвчтөн гэнэтийн үйлдлийн улмаас өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй байдаг. Иймд 2-4 гр хлоралгидратаар клизм тавьж тайвшруулж болно.

99. Эпилепсийн таталтуудын хооронд өвчтөн эпилепсийн статуст орж болно. Эсвэл таталтуудын хооронд ухаан саруул байж болно.

100. Галоперидолыг огцом өндөр тунгаар эмчилгээнд хэрэглэхэд нейролептикийн хорт хамшинж үүсдэг. Ийм учраас өвчтөнд диазепамыг хэрэглэж булчингийн хөшилтийг бууруулна.

Сорилын хариу-2

1. A
2. B
3. B
4. E
5. A
6. C
7. E
8. B
9. D
10. B
11. A
12. C
13. E
14. B
15. D
16. A
17. C
18. C
19. A
20. A
21. B
22. A
23. E
24. D
25. E
26. D
27. E
28. E
29. A
30. D
31. B
32. E
33. E
34. C

35. E
36. A
37. B
38. E
39. A
40. A
41. B
42. C
43. B
44. A
45. D
46. C
47. C
48. A
49. D
50. C
51. B
52. A
53. C
54. D
55. C
56. A
57. B
58. E
59. D
60. B
61. E
62. C
63. D
64. A
65. C
66. A
67. C
68. E

69. A
70. A
71. C
72. A
73. E
74. D
75. B
76. E
77. A
78. C
79. A
80. D
81. E
82. E
83. B
84. C
85. E
86. A
87. E
88. A
89. B
90. C
91. A
92. E
93. B
94. C
95. E
96. D
97. A
98. C
99. D
100.

A